

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН БОДЛОГО ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН 3.СЭРГЭЛЭНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
Зорилт 1. “САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ”							
1.	Арга хэмжээ 1.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 109 хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар, орон нутагт сурталчлан таниулна.	Арга хэмжээний тоо	-	1	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 109 хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөс архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой өөрчлөлтийг таниулах зорилгоор “Төрийн архивын удирдах ажилтан, улсын байцаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-д оролцож, Цахим шилжилтийн бодлого, хууль эрх зүйн орчин сэдвээр илтгэл мэдээлэл 100 орчим албан хаагчдад хүргэсэн. Мөн 2024 оны 8 дугаар сарын 9-ны өдөр Цахим шилжилт-Төрийн байгууллагад хиймэл оюун ухааны хэрэглээ сэдвээр мөн 70 орчим албан хаагчдад 1 цагийн илтгэл танилцуулсан.	2024.04.25	100

2.	Арга хэмжээ 1.2. Төрийн цахим шилжилтэд хиймэл оюун ухаан ашиглах бодлогын чиглэл батлуулна.	Батлуулсан бодлогын чиглэлийн тоо	-	1	Төрийн цахим шилжилтэд хиймэл оюун ухаан ашиглах бодлогын чиглэлийн төслийн эхний хувилбарыг боловсруулах зорилгоор бусад улсын туршлагын талаарх судалгааны ажлыг хийсэн. Мөн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. "Их өгөгдөл, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах" ажлын даалгавар боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.	2024.04.01-12 сар	70
Зорилт 2. "ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, НЭВТРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ"							
3.	Арга хэмжээ 2.1. Мэдээллийн технологийн энтрепенёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран арга хэмжээ зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	1. Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкатай хамтран "Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжих талаар мэдээлэл цуглуулах, баталгаажуулах" хамтран хэрэгжүүлж буй төслийн ажлын хэсгийн цувралт уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2024 оны 05 дугаар сарын 01-ний А/204 дүгээр тушаалаар байгуулагдсан Азийн Шинжлэх Ухааны Паркуудын холбоо (ASPA)-ны 27 дугаар чуулга уулзалтыг нийт 400 гаруй, үүнээс Азийн орнуудаас 60 гаруй төлөөлөгчийг оролцуулж 2024 оны 8 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд анх удаа Монгол Улсад зохион байгуулсан.	2024.04.19 2024.04.25- 2024.09 сар	100

4.	Арга хэмжээ 2.2 Салбарын судалгаа, шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээ зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	1. Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи хооронд 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 33/22 дугаар Хамтын ажиллагааны санамж бичиг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2024 онд хэрэгжүүлэх ажилд тусгасны дагуу ШУА-ын Математик, тоон технологийн хүрээлэнтэй хамтран ажиллаж байна. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/125 тоот тушаалаар байгуулагдсан Монголын Инновацын 7 хоног-2024 арга хэмжээг Эрдэнэт үйлдвэрийн судалгаа, шинжилгээний төвтэй хамтран зохион байгуулсан.	2024.04.02 2024.04.15 2024.04.22-26	100
Зорилт 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"							
5.	Арга хэмжээ 3.1. ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах	Батлуулсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо	-	1	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулсан.	2024.04 сар	100
6.	Арга хэмжээ 3.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хүргүүлсэн биелэлтийн тоо	-	3	Чиг үүргийн дагуу Бодлого, төлөвлөлтийн газрын сарын тайланг тухай бүр нэгтгэн, холбогдох засварыг оруулж эцэслэн газрын даргад танилцуулснаар Төрийн захиргааны удирдлагын газарт тухай бүр хүргүүлсэн.	2024.04.25 2024.05.25 2024.12 сар	100
7.	Арга хэмжээ 3.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Баримт бичгийн тоо	-	91	Холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн, боловсруулсан нийт 91 албан бичиг, 1 өргөдөлд тухай бүр хариу өгч ажилласан. Мөн нэг өргөдлийг 16 хоногт шийдвэрлэж ажилласан.	2024.04.01-06 сар	100

8.	Арга хэмжээ 3.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	ХАСХОМ маягтын тоо, Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийн тоо	-	1	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд тусгасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн.	2024.04.30	100
----	--	---	---	---	---	------------	-----

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжүүлэх үндэсний зөвлөлийг бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журам боловсруулах	Журмын төслийн тоо	-	2	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжүүлэх үндэсний зөвлөлийг бүрэлдэхүүн, түүний ажиллах журам болон виртуал бүсийн ажиллах журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өрийн А/05 тушаалаар байгуулж эхний хурлыг 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар журмын 2 төсөл боловсруулан танилцуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг нийт 6 удаа зохион байгуулж, 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжүүлэх үндэсний зөвлөлийг бүрэлдэхүүн, түүний ажиллах журам"-ыг хэлэлцүүлж батлуулсан. Тус журмын дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжүүлэх үндэсний зөвлөлийг анхдугаар	2024.08.01- 2024.11.25	100

				хуралдааныг холбогдох бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж, Анхдугаар хуралдаанаар 1.Үндэсний зөвлөлийн хуралдааны дэг, 2."Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг зохицуулах журам"-ыг боловсруулах ажлын хэсэг, 3.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийн хөгжүүлэх виртуал бүсийн стратеги боловсруулах ажлын хэсэг байгуулах Үндэсний зөвлөлийн тогтоол гарахаар шийдвэрлэсэн. Тус ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой дараах албан бичгүүдийг боловсруулсан: 1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны ажиллах журмын төсөлд хүргүүлэх саналыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03/1000 тоот албан бичгээр Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ-т, 2.Үндэсний зөвлөлийн хуралдааны дэг, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, ажлын хэсэг зохион байгуулахтай холбогдох саналыг боловсруулж 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/946 дугаартай албан бичгийг Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ-т, 3. Анхдугаар хуралдааныг зохион байгуулахтай холбогдуулан мэдээлэл хүргэх, урилга хүргүүлэх албан бичгийг боловсруулан 2024 оны 11 сарын 22-ны өдрийн 03/967, 01/968 бичгүүдэр Сангийн сайд болон Эдийн засаг хөгжлийн сайд нарт хүргүүлсэн. Мөн холбогдох хуралдаан, ажлын хэсгийн	
--	--	--	--	--	--

					уулзалтуудад шаардлагатай Ерөнхий сайдын хэлэх үг, Ц.Баатархүү сайдын хэлэх үгийн тус бүр бэлдсэн.		
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг эхлүүлэх	Баримт бичгийн тоо	-	2	Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн төсөлд "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн тухай хуулийн төслийг боловсруулах тухай" санал боловсруулж, Хуулийн хэлтсээс тус саналыг тусган 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/334 дугаар албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. Мөн Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах талаар холбогдох судалгаа хийх, тус бүсийг байгуулахад шаардлагатай дүрэм, журмын төсөл болон үйл ажиллагаанд нэвтрүүлэх санал боловсруулж, туршилтын бүсийн байршлыг тодорхойлох үүрэг бүхий Ажлын хэсгийг тус яамны сайдын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/23 дугаар тушаалаар байгуулсан. Мөн Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүсийг өргөтгөсөн радиуст буюу Төв аймгийн Баяндэлгэр сум, Налайхын цэргийн ангийн орчим болон төслөөр тодорхойлсон байршилд байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан тус яамны ТНБД-аар батлуулж, Монгол Улсын Шадар сайдын харьяа Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлэн тус нээлттэй тендэрийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зарлаж 12 дугаар сарын 13-ны өдөр нээхээр tender.gov.mn дээр байрлуулсан байна.	2024.11.15	100
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб байгуулах ТЭЗҮ, зураг төсөл	Баримт бичгийн тоо	-	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих, инновацын дэд бүтцийг бий болгох зорилгоор Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб байгуулах ТЭЗҮ, зураг төсөл	2024.11.15	100

	боловсруулах ажлын даалгавар батлуулж хүргүүлэх				боловсруулах ажлын даалгавар боловсруулж тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр батлуулан 03/862 дугаартай албан бичгийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд хүргүүлсэн. Тус ажлын даалгаврын хамт үнэлгээний хороонд орж ажиллах холбогдох албан тушаалтан (Ч.Гүнсэнхорол, Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтсийн дарга)-ы мэдээллийг хамтатган илгээсэн. Тус албан бичгийн дагуу энэхүү тендер 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зарлагдан 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр нээхээр зарласан.		
4	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөлд инновацын холбогдох хэсгийг боловсруулах	Саналын тоо	-	1	"Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөл"-д тусгах инновацын чиглэлийн өөрчлөлтийн төслийн саналыг Хуулийн хэлтэстэй хамтран боловсруулан нэгтгэлд хүргүүлсэн. Тус нэгтгэл албан бичиг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/11 дугаартай албан бичгээр хүргэгдэж, Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор батлагдсан.	2024.07.16-2024.08.21	100
5	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Инновацын бодлого, зохицуулалтын газар, холбогдох хэлтсийн албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах	Баримт бичгийн тоо	-	12	Инновацын бодлого, зохицуулалтын газар, холбогдох хэлтсийн албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг хянан нэгтгэж ТЗУГ-т хүргүүлсэн.	2024.11.01-2024.11.25	100
6	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны чиглэлээр Эхний 100 хоногт хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулах	Саналын төсөл	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны чиглэлээр Эхний 100 хоногт хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний саналыг холбогдох газар хэлтсүүдтэй хамтран боловсруулж 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв.	2024.07.16-2024.07.22	100

					Мөн тус төлөвлөгөөний саналд оруулсан ажлуудын нэмэлт тайлбарыг нэгтгэсэн.		
7	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Гадаад хамтын ажиллагааны болон харилцан ойлголцлын санамж бичигт санал өгөх	Саналын тоо	-	1	Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ-аас ирүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан улсын Програм хангамж ба мэдээллийн технологийн парк, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гвангжу Технопарктай хамтын ажиллагааны санамж бичгийн төсөл	2024.01.02-2024.06.10	100
8	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгээр хийгдэх "Нээлттэй өгөгдөл ашиглах хөтөлбөр боловсруулах" төсөл хэрэгжүүлэн ажиллах	Хэрэгжүүлсэн төсөл	-	1	Нээлттэй өгөгдөл дээр тулгуурлан эрүүл мэндийн салбарын асуудлыг шийдэх туршилтын загвар /прототайп/ бүтээх хакатон зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, удирдамж боловсруулж, олон нийтэд нээлттэйгээр 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 26-ны өдөр хүртэл зарлсан. Тус хакатон тэмцээнд оролцох хүсэлт ирүүлсэн 13 байгууллагуудын материалыг хянаж 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр эхний шатны шалгаруулалтыг хийж тэнцсэн 8 байгууллагад мэдэгдлийг хүргүүлсэн. Төгсгөлийн шатны шалгаруулалтыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 09 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 8 баг эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор нээлттэй өгөгдлийг ашиглан, бизнесийн загваруудыг боловсруулж танилцуулсан. Тус хакатон тэмцээний тэргүүн байранд "Rookie systems", дэд байранд "Data med" багууд шалгарсан.	2024.01.09-2024.06.10	100
9	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Засгийн газрын гадаадын зээл тусламж, удирдлага зохицуулалтын чиглэлээр яамд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын чадавх бэхжүүлэх уулзалт хэлэлцүүлэгт оролцох	Уулзалт, хэлэлцүүлгийн тоо	-	1	Сангийн яамнаас зохион байгуулсан Засгийн газрын гадаадын зээл тусламж, удирдлага зохицуулалтын чиглэлээр яамд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын чадавх бэхжүүлэх уулзалт хэлэлцүүлэгт Блю Скай зочид буудлын хурлын танхимд оролцсон.	2024.05.09	100

10	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хийх уулзалтын ярианы сэдэв бэлтгэх, уулзалтад оролцох	ЖАЙКА-тай хийх уулзалтын тоо	-	2	Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хийх уулзалтын ярианы сэдэв бэлтгэж, 5 удаагийн уулзалтад оролцон холбогдох дараагийн шатны уулзалтуудыг зохион байгуулсан.	2024.04.23, 2024.04.25	100
11	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 11. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас жил тутам зохион байгуулдаг Мэдээлэл холбооны салбар дахь охидын манлайлал /Girls in ICT/ арга хэмжээнд ТНБД-ын илтгэл бэлдэж оролцох	Илтгэлийн материалын тоо	-	1	Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас жил тутам зохион байгуулдаг Мэдээлэл холбооны салбар дахь охидын манлайлал /Girls in ICT/ арга хэмжээнд ТНБД-ын илтгэл бэлдэж оролцсон.	2024.04.17	100
12	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 12. Монгол Улсын Эдийн засгийн форум зохион байгуулах	Арга хэмжээний тоо	-	1	"Go Mongolia" уриан дор зохион байгуулагдсан Монголын Эдийн Засгийн Чуулган зохион байгуулахад Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран чуулганы салбар хуралдаан болох "Дижитал засаглал ба дижитал эдийн засаг-гаргасан ахиц" сэдвээр хэлэлцүүлгийн ярилцах сэдэв, сэтгүүлд нийтлэгдсэн Дижитал эдийн засгийн чиглэлээрх ярилцлага, холбогдох бэлтгэл ажлыг ханган хурлыг зохион байгуулсан.	2024.7.8-9	100
13	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 13. Гадаад харилцааны чиглэлээр бусад улстай хамтран ажиллах	Хамтран ажиллах талаар санал боловсруулсан тоо	-	5	Гадаад харилцааны чиглэлээр бусад улстай хамтран ажиллах талаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг нэгтгэх зорилгоор боловсруулж буй жагсаалтад Бүгд Найрамдах Узбекистан Улс, Япон, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камероны Монгол Улсад хийсэн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ажлуудыг оруулж баяжуулсан.	?	?

14	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 14. Төсвийн төсөлд санал өгөх	Саналын тоо	-	1	2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд санал боловсруулж, СХОХ-т (munkhsolongo@mddc.gov.mn) хүргүүлсэн.	2025.08.30	100
15	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 15. Тайлан гаргах	Тайлангийн тоо	-	9	Бодлого, төлөвлөлтийн газрын 2024 оны эхний хагас жилийн тайланг гарган Төрийн захиргааны удирдлагын газрын тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. Мөн газар доторхи ажлын хуваарилалтын дагуу 2024 оны 4 сараас хойших бүх сарын тайланг нэгтгэн ТЗУГ-т тухай бүр хүргүүлсэн.	2024.04.01- 12.31	100
16	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 16. Бусад улстай болон дотоодод хамтран ажиллах талаар хэлэх үг, ярианы сэдэв, хамтран ажиллах санал	Ярианы сэдэв, хамтран ажиллах саналын тоо	-	13	1. ; “Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой хөгжилд цахим инновацыг ашиглах нь” сэдвийн хүрээнд зохион байгуулах НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 80 дугаар чуулганд Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн хэлэх үгийн төсөлд санал боловсруулж, 2024 оны 4 дүгээр сарын 03/803 дугаартай бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. 2. Япон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ийн төлөөлөгчидтэй 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хийсэн уулзалтын ярианы сэдэв 3. УИХ-ын дарга Г.Занданшатар Япон улсын Токио хотноо зохион байгуулагдах Азийн ирээдүй форумд үндсэн илтгэгчээр уригдан оролцохтой холбогдуулан цахим хөгжил, шилжилтийн өнөөгийн байдал, ололт амжилт болон тулгарч буй сорилтын талаарх мэдээлэл, холбогдох саналыг боловсруулж, 2024 оны 5 дугаар сарын 02-ны 03/964 дүгээр албан бичгээр хүргүүлэв. 4. Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг Япон Улсад Ази, Номхон Далайн цахилгаан	2024.04.01- 12.31	100

				холбооны байгууллагаас зохион байгуулах дээд түвшний албан хаагчдад зориулсан бодлого боловсруулах уулзалтад танилцуулах Монгол улсын цахим шилжилтийн өнөөгийн байдлын талаарх танилцуулга, хэлэлцүүлгийн үеэр ирэх асуултын хариулт, хүлээн авалтын үеэр хэлэх үг; 5.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камероны 2024 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал; 6. Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 2026 онд шинээр хэрэгжүүлэх төслийн саналд Мэдээллийн технологийн судалгаа хөгжүүлэлтийн /R&D/ төв байгуулах төслийн санал боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 03/1267 дугаартай албан бичгээр Сангийн Яаманд хүргүүлсэн. 7.Швейцарийн Холбооны Улсын Харилцаа холбоо, систем, мэдээллийн технологи хариуцсан албатай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах төслийг боловсруулсан. 8. Австралийн Холбооны Улсын Элчин сайд Кэйти Смитийн тус яамны сайдтай уулзах уулзалтын үеэр ярилцах ярианы сэдэв бэлдсэн. 9. Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр дагалдаж ирэх компаниудын төлөөллийг тодорхойлж хүргүүлсэн. Мөн айлчлалын үед хэлэлцэх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны		
--	--	--	--	---	--	--

					яам болон Бүгд Найрамдах Словени Улсын Дижитал шилжилтийн яамны хооронд байгуулах Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулсан. 10. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Програм хангамж ба мэдээллийн технологийн парк, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гвангжу Технопарктай тус тус байгуулахаар төлөвлөж буй "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т оруулах саналыг боловсруулсан. 11.ТНБД-ын Америкийн Нэгдсэн улсад хийх айлчлалын үеэр шаардлагатай материалыг хамтын ажиллагааны бүх талаар шаардлагатай байж болох мэдээллийг багц байдлаар бэлтгэн Гадаад хамтын ажиллагааны хэлтэст өгсөн. 12. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин Сайд С.Сүхболд Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны Сайд И Жун Ху-той уулзах үеэр ярих ярианы сэдвийг бэлдэж хэлтсийн даргад танилцуулав. 13. Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ-аас ирүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан улсын Програм хангамж ба мэдээллийн технологийн парк, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гвангжу Технопарктай хамтын ажиллагааны санамж бичгийн төсөл		
17	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 17. Олон улсын заал, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал боловсруулах	Боловсруулсан төслийн	-	1	Сангийн яамнаас ирүүлсэн саналын дагуу Япон улсын буцалтгүй тусламжаар хийгдэх Стартапын экосистемийг бий болгох төслийг боловсруулан хүргүүлсэн.	2024.7.8	100

		саналын тоо					
18	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 18. Инкубаторын үнэлгээний комисст ажиллах	Ажилласан комиссын хурлын тоо	-	2	Мэдээллийн технологийн инкубаторын 51, 52 дах элсэлт, сунгалтын комисст тухай бүр тушаалын дагуу ажиллаж байна. Сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нийт 14 компаниас "Лингорс" ХХК, "Метаког метрикс" ХХК-ууд дээрх шалгуур үзүүлэлтүүдийг хангаж Мэдээллийн Технологийн Үндэсний Парк-ын инкубаторын хөтөлбөрт хамрагдахаар болсон.	2024.9.25, 2024.10.23	100
19	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 19. Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл боловсруулах	Төслийн санал	-	1	Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг холбогдох газар, хэлтэстэй хамтран боловсруулж, Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлэхээр бэлтгэсэн. Тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд нийт 18 төрлийн инновацийн, хиймэл оюун ухаан их өгөгдлийн, гарааны бизнесийн болон мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлийн ажлуудыг МТҮП ТӨААТҮГ болон И- Монгол Академи УТҮГ-ээс санал авч боловсруулсан.	2024.10.22	100
20	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 20. 2024 оны гурав, дөрөвдүгээр улиралд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт гаргах	Жагсаалты н төсөл	-	1	Тус яамнаас цахим хөгжил, инновац, харилцаа холбооны чиглэлээр 2024 оны гурав, дөрөвдүгээр улиралд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг холбогдох газруудтай хамтран боловсруулсан.	2024.10.21	100
21	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 21. Албан бичиг шийдвэрлэх	Албан бичгийн тоо	-	91	Нийт албан бичиг шийдвэрлэж ажиллав: 1.Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Хиймэл оюун ухааныг ашиглах журам боловсруулах ажлын хэсэгт нэр хүргүүлэх тухай 2024 оны 07 дугаар сарын 30-ний өдрийн 03/52 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. 2. Гадаад харилцааны яамнаас 2024 оны 7 дугаар сарын 26-ний өдрийн 06/3420 дугаартай албан бичгээр ирүүлсэн Засгийн	2024.04.01- 2024.12.20	100

					газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд холбогдох хариуг хүргүүлсэн. 3.Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдөр ХЭГ/1293 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн төсөлд холбогдох саналыг 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 01/19 тоот албан бичгээр хүргүүлсэн. 4. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн 2024 оны 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Тайландын Хаант Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 01/994 дүгээр албан бичгээр хүргүүлэв. 5. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдөр ХЭГ/1293 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн төсөлд холбогдох саналыг 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 01/19 тоот албан бичгээр хүргүүлсэн. 6. Бусад холбогдох асуудлуудаар 2024 оны 4 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 20-ныг хүртэл нийт ирсэн 91 бичигт хариу өгч ажиллаж байна.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад	Тухай бүр холбогдох хурал,	-	тухай бүр	Хиймэл оюун ухааны хэрэглээ, цаашдын чиг хандлага форум, Монголын	2024.04.10 2024.04.11	100

	газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцох	зөвлөгөөнд хамрагдсан байна.			үнэт металлын форум, Монголын инновацийн 7 хоног, Шинжлэх ухааны ажилтны хоёрдугаар их хурал, тус тус оролцсон.	2024.04.22-26 2024.05.16	
2.	Арга хэмжээ 2. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Тухай бүр холбогдох сургалт, семинарт хамрагдсан байна.	-	тухай бүр	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтад тогтмол оролцсон. Төрийн албаны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж байна.	2024.04.01-12 сар	100

САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН БОДЛОГО
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

...*З.Сэргэлэн*..... / З.СЭРГЭЛЭН /

(Нэр, гарын үсэг)

...2024/12/06..

(Огноо)